

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/04/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn	Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
	Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Чойр хот 2022 он	Аудитор: С.Батцэцэг Утас: 70543179 Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	16
8.3 Албан шаардлага	16
8.4 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1. Аудитын санал дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2022.03.15 № 54
танай _____ -ны № _____ -г

“ИЛЧЛЭГ ШИВЭЭ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ш. ЧИНБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

019020165

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,152,924.97	77,131,428.13
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	813,557.14	8,738,394.01
3	Кассанд байгаа бэлэн мөнгө		333,672
4	Төгрөг		333,672
5	Банкинд байгаа бэлэн мөнгө	813,557.14	8,404,722.01
6	Төгрөг	813,557.14	8,404,722.01
7	Арилжааны банк дахь харилцах	813,557.14	8,404,722.01
8	АВЛАГА	28,326,425.51	35,364,206.32
9	Ажиллагчидтай холбогдсон авлага	320,000	584,648.78
10	Бусад авлага	28,006,425.51	34,779,557.54
11	Байгууллагаас авах авлага	28,006,425.51	34,779,557.54
12	БАРАА МАТЕРИАЛ	82,012,942.32	33,028,827.8
13	Бэлэн бүтээгдэхүүн		911,217.72
14	Хангамжийн материал	82,012,942.32	32,117,610.08
15	Бичиг хэргийн материал		406,436.52
16	Аж ахуйн материал	82,012,942.32	27,596,893.87
17	Сэлбэг хэрэгсэл		1,066,750
18	Түлш, шатах тослох материал		454,544.94
19	Бусад хангамжийн материал		2,592,984.75
20	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,357,903,663.95	1,764,157,598.07
21	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,357,903,663.95	1,764,157,598.07
22	Биет хөрөнгө	1,332,884,913.95	1,733,643,961.71
23	Барилга, байгууламж, орон сууц	195,739,889	195,739,889
24	Хуримтлагдсан элэгдэл	-10,912,453.84	-16,203,729.28
25	Авто-тээврийн хэрэгсэл	24,960,000	2,000,000
26	Хуримтлагдсан элэгдэл	-24,960,000	
27	Машин тоног төхөөрөмж(компьютер)	542,536,073	729,524,231
28	Хуримтлагдсан элэгдэл	-307,469,718.02	-112,864,094.71
29	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,924,001	42,473,831.81
30	Хуримтлагдсан элэгдэл	-34,375,920.67	-24,581,597.84
31	Бусад үндсэн хөрөнгө	980,492,271	1,049,629,271
32	Хуримтлагдсан элэгдэл	-98,049,227.52	-147,073,839.27
33	Дуусаагүй барилга, байгууламж	15,000,000	15,000,000
34	Биет бус хөрөнгө	25,018,750	30,513,636.36
35	Програм хангамж	3,300,000	8,163,636.36
36	Хуримтлагдсан элэгдэл	-2,431,250	-1,800,000
37	Бусад биет бус хөрөнгө	24,150,000	24,150,000
38	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,469,056,588.92	1,841,289,026.2
39	НИЙТ ӨР ТӨЛБӨР	287,707,326.79	831,218,871.68
40	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	230,582,326.79	211,763,871.68
41	Өглөг	230,582,326.79	211,763,871.68
42	Бусад өглөг	230,582,326.79	211,763,871.68
43	Байгууллагад төлөх өглөг	230,582,326.79	84,919,065.36
44	Татварын өглөг /ТӨҮГ/		46,943,350.01
45	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		79,901,456.31
46	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	57,125,000	619,455,000

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

47	Урт хугацаат зээл	57,125,000	619,455,000
48	Төгрөг	57,125,000	619,455,000
49	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	57,125,000	619,455,000
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,181,349,262.13	1,010,070,154.52
51	Засгийн газрын хувь оролцоо	1,181,349,262.13	1,010,070,154.52
52	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,337,169,892	2,337,169,892
53	Хуримтлагдсан үр дүн	-1,909,218,495.12	-2,085,997,602.73
54	Өмнөх үеийн үр дүн	-1,775,802,318.06	-1,909,218,495.12
55	Тайлант үеийн үр дүн	-133,416,177.06	-176,779,107.61
56	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	753,397,865.25	758,897,865.25
57	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,469,056,588.92	1,841,289,026.2

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-43,026,080.96	52,708,436.71
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-43,026,080.96	52,708,436.71
3	Нийтлэг татварын бус орлого	-43,026,080.96	52,708,436.71
4	Бусад орлого	2,715,758.74	6,000
5	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	422,802,024.66	549,982,536.59
6	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	468,543,864.36	497,280,099.88
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	90,390,096.1	148,391,575.05
8	УРСГАЛ ЗАРДАЛ	90,390,096.1	148,391,575.05
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,390,096.1	148,391,575.05
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,390,096.1	148,391,575.05
11	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	90,390,096.1	148,391,575.05
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-133,416,177.06	-95,683,138.34
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		81,095,969.27
14	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		81,095,969.27
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-133,416,177.06	-176,779,107.61

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,775,802,318.06	1,314,765,439.19
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,775,802,318.06	1,314,765,439.19
3	Тайлант үеийн үр дүн			-133,416,177.06	-133,416,177.06
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,909,218,495.12	1,181,349,262.13
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,909,218,495.12	1,181,349,262.13
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,909,218,495.12	1,181,349,262.13
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		1,500,000		1,500,000
8	Өмчид гарсан өөрчилөлт		4,000,000		4,000,000
9	Тайлант үеийн үр дүн			-176,779,107.61	-176,779,107.61
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,337,169,892	758,897,865.25	-2,085,997,602.73	1,010,070,154.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	395,543,057.59	497,586,655.29
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	395,543,057.59	497,586,655.29
3	Нийтлэг татварын бус орлого	395,543,057.59	497,586,655.29
4	Бусад орлого	64,322.91	6,000
5	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	392,796,792.68	497,536,722.29
6	Даатгалын нөхвөрөөс хилээн авсан мөнгө /ТӨҮГ/	2,681,942	43,933
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,422,820.88	474,025,637.61
8	УРСГАЛ ЗАРДАЛ	384,422,820.88	474,025,637.61
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,422,820.88	474,025,637.61
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,751,962	147,201,185
11	Үндсэн цалин	122,751,962	147,201,185
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,116,635	36,171,496.73
13	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	8,116,635	36,171,496.73
14	Хангамж, бараа материалын зардал	34,515,230	25,543,944.54
15	Бичиг хэрэг	904,430	438,554.54
16	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800	2,036,930
17	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,000	290,000
18	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	32,400,000	22,778,460
19	Эд хогшил, урсгал засварын зардал	1,247,360.99	3,515,000
20	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,247,360.99	3,515,000
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	217,791,632.89	261,594,011.34
22	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,487,980	
23	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	6,000,000	43,852,884.65
24	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	210,303,652.89	217,741,126.69
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,120,236.71	23,561,017.68
26	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,877,000	15,636,180.81
27	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,877,000	15,636,180.81
28	Дотоод эх үүсвэрээр	10,877,000	15,636,180.81
29	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	500,000	
30	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	10,377,000	15,636,180.81
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,877,000	-15,636,180.81
32	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	243,236.71	7,924,836.87
33	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	570,320.43	813,557.14
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	813,557.14	8,738,394.01

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг анхаарах, өглөг, авлагыг барагдуулах талаар тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 20 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүү, хяналт аудитын албанаас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 90,390.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,355.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0% буюу 1,016.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын зорилго нь “Ус хангамж, ус цэвэрлэгээ, дулаан хангамжийн үйлчилгээг хэрэглэгчдэд чанартай найдвартай хүргэх”-д оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дулаанаар хангах
- Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг цэвэр бохир ус түгээх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ-ыг 1990 оны 8 дугаар сард Дорноговь аймгийн Эрчим хүчний нийтийн үйлдвэрийн даргын тушаалаар Шивээговь салбарыг бие даасан салбар болгон Дорноговь аймгийн Сүмбэр сум (одоогийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум) Даланжаргалан сумдыг харьяалуулан зохион байгуулан бие даан үйл ажиллагаа явуулах эрх олгосон байна.

Компанийн удирдлагыг Говьсүмбэр аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ба ТУЗ байгуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд ашиглалтын хугацаа дууссан 357,251.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, шинээр 575,830.0 мянга, балансаас балансад 357,251.1 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн

байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдөөгүй, орон тоог бууруулаагүй боловч 24 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	813.6	8,738.4	7,924.8
БХХО	0.0	0.0	0.0
Авлага	28,326.4	35,364.2	7,037.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	82,012.9	33,028.8	-48,984.1
Үндсэн хөрөнгө	1,332,884.9	1,733,644.0	400,759.1
Биет бус хөрөнгө	25,018.8	30,513.6	5,494.8
Нийт хөрөнгийн дүн	1,469,056.6	1,841,289.0	372,232.4
Өр төлбөрийн дүн	287,707.3	831,218.9	543,511.6
Богино хугацаат өглөг	230,582.3	211,763.9	-18,818.4
Урт хугацаат өглөг	57,125.0	619,455.0	562,330.0
Эздийн өмч	1,181,349.3	1,010,070.1	-171,279.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,469,056.6	1,841,289.0	372,232.4

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 7,924.8 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэл 35,364.2 мянган төгрөг бөгөөд ААНБ, айл өрхийн цэвэр бохир усны төлбөрийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 34,709.3 мянган төгрөгөөр тооцоо нийлсэн актаар баталгаажсан, өмнөх нягтлан бодогч Т.Буянзаяагаас авах 654.9 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,028.8 мянган төгрөг болж 48,984.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд аж ахуйн материалын данс 47,778.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг тайлант онд залруулсан, бараа материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 177,122.3 мянга, зарцуулалт 180,751.9 мянган төгрөгөөр бараа материалын тайланг тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,733,644.0 мянган төгрөг болж 400,759.1 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн худалдан авалт, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь худалдан авсан 21,999.7 мянга, Шивээговь сумын ОНХС-аар үнэ төлбөргүй хүлээн авсан 81,597.0 мянга, аймгийн ИТХ-ын 2021 оны 23,38,40 дугаартай тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн 486,233.1 мянга, хөрөнгийг дахин үнэлж хүлээн авсан 1,500.0 мянга, нийт 589,829.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол АИТХ-ын 47, 56 тогтоолоор 2,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэхээр данснаас хассан, 355,751.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, нийт 359,251.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 30,513.6 мянган төгрөг болж 5,494.8 мянган төгрөгөөр өссөн нь төвийн худагт суурилуулсан ухаалаг системийг үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 230,582.3 мянга, урт хугацаат өр төлбөр дансанд 619,455.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Богино хугацаат өр төлбөр нь “Шивээ-Овоо” ХК-д 84,919.1 мянга, Татварын хэлтэст 46,943.4 мянга, Нийгмийн даатгалын хэлтэст 79,901.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Урт хугацаат өр төлбөр нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос үүссэн хойшлогдсон татварын өглөг бүртгэснээс шалтгаалсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын орлогч Б.Анхбаяраар 2021 оны “Зуны их засварын ажлын төлөвлөгөө”-г УТХО-аар 300,000.0 мянга, ОНХС-аар 100,000.0 мянга, өөрийн хөрөнгөөр 146,200.0 мянга, эх үүсвэргүйгээр 242,000.0 мянган төгрөгөөр хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлуулсан байна. Тайлант оны нийт орлогыг 560,359.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 987,253.3 мянган төгрөгөөр, 426,893.6 мянган төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 549,982.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 726,761.6 мянган төгрөгийн зардал гарган 176,779.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын дэлгэрэнгүй тайланд 549,982.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 726,761.6 мянган төгрөгийн зардал гарган, 176,779.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлого 279,927.8 мянга, Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс айл өрх, ААН-ийн халаалтын хөнгөлөлтөд 110,007.4 мянга, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 107,651.4 мянган төгрөгийн цэвэр бохир усны зардлын хөнгөлөлтийн орлогоос тус тус бүрджээ.

Нийт зардлын гүйцэтгэл 726,761.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 260,491.7 мянган төгрөг буюу 26.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 6 ажлыг өөрийн орлогын эх үүсвэрээс 44,801.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 176,779.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөснөөс 250,114.5 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 643,039.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 74,819.4 мянган төгрөгийн 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 10 хөрөнгө зарцуулсан тушаал мэдээлээгүй, 20 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, ТБОНӨХБАҮХАТ хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 44,973.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 44,973.3 мянган төгрөгийг залруулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар татгалзсан санал дүгнэлт авсан учир зөвлөмж өгөгдөөгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 154,489.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 59,303.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 95,185.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 59,303.5 мянган төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- 8.1.1. Завсрын аудитаар нярвын бараа материалын тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгын тайлангийн эхний үлдэгдэл нь 32,379.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг зөвлөмж өгч залруулсан.
- 8.1.2. Завсрын аудитаар 12,594.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж өгч залруулсан.
- 8.1.3. Завсрын аудитаар үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 8.1.4. Төсөвт байгууллагуудын гэрээний заалтыг зөрчин гэрээнд өөрчлөлт оруулалгүйгээр жилийн дундуур халаалт болон цэвэр, бохир усны зардлын үйлчилгээний төлбөрийг нэмэгдүүлж үндэслэлгүйгээр 14,330.1 мянган төгрөгийн авлага үүсгэснийг аудитын явцад залруулсан.

8.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

8.3 Албан шаардлага

8.3.1 Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 5 худалдан авалт, 10 хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэр мэдээлээгүй, 20 мэдээллийг хугацаа хоцроосон нийт 74,819.4 мянган төгрөгийн зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.9 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.3.2 Нярвын бараа материалын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгыг 2,717.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.3.3 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.4 дэх заалтыг зөрчиж 24 ажилтанд 4,042.8 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгож, албан тасалгааны

тавилгыг 1,050.0 мянган төгрөгөөр худалдан авч нийт 5,092.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.4 дэх заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.3.4 Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 12,556.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэх болон шаардлага хангаагүй үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулах

2. Өглөг, авлагын хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ААНБ, айл өрхөөс авах 28,412.9 мянган төгрөгийн авлага, 206,381.8 мянган төгрөгийн өр төлбөрийн барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Өмнөх онуудын болон тайлант хугацаанд үүссэн өглөг, авлагыг барагдуулах
ГСА-2022/04/СТА-ОНӨААН

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь гаргаж, төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/								
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Няrvын бараа материалын тайлангийн эхний үлэгдэл болон санхүүгийн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл зөрүүтэй		1	32,379.1	1	32,379.1							
2	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй		1	12,594.2	1	12,594.2							
3	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад биет бус хөрөнгийн няrvын тайланг гаргаагүй		1	0	1	0.0							
4	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Төсөв байгууллагуудын гэрээний заалтыг зөрчин гэрээнд өөрчлөлт оруулалгүйгээр жилийн дундуур халаалт болон цэвэр бохир усны зардлын үйлчилгээний төлбөр нэмэгдүүлсэн		1	14,330.1	1	14,330.1							
5	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.4 дэх заалтыг зөрчиж үр дүнгийн урамшуулал олгосон, албан тасалгааны тавилга худалдан авсан	Тогтоол зөрчиж үр дүнгийн урамшуулал олгож, тавилга худалдан авсан	1	5,092.8					1	5,092.8			
6	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА-2022/04/СТА-ОНӨААН	Няrvын тайлан, санхүүгийн тайланг зөрүүтэй тайлагнасан / Сангийн сэлбэг, цэвэрлэгээний материал, түлш шатахууны материал, аж ахуйн материал, түүхий эд материал,	Бараа материалын тайланг зөрүүтэй тайлагнасан	1	2,717.5					1	2,717.5			

“Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			автомашинны сэлбэг, хангамжийн материал/												
7	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА- 2022/04/СТА- ОНӨААН	Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүйгээс зөрүүтэй шивэгдсэн	Худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй	1	12,556.0					1	12,556.0			
8	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА- 2022/04/СТА- ОНӨААН	Элэгдлээ бүрэн нөхсөн 23 үндсэн хөрөнгө бүртгэлтэй хөрөнгүүдийг актлах болон ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийгээгүй	Үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын талаар	1	0,0								1	0,0
9	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА- 2022/04/СТА- ОНӨААН	ААНБ, айл өрхөөс авах 28.412.9 мянган төгрөгийн авлага, 206,381.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй	Авлага, өглөг барагдуулах	1	0,0								1	0,0
ДҮН					9	79,669.7	4	59,303.5			3	20,366.3		2	0,0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	“Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ	ГСА- 2022/04/СТА- ОНӨААН	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 20 мэдээллийн хугацаа хоцроосон, 10 тушаал, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд нийт 74,413.5 мянган төгрөгийг мэдээлээгүй	Шилэн дансан мэдээлэл дутуу оруулсан.	1	74,819.4					1	74,819.4			
ДҮН					1	74,819.4					1	74,819.4			
НИЙТ ДҮН					10	154,489.2	4	59,303.5			4	95,185.7		2	0,0